


Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны  
06 дугаар сарын 24-ны өдрийн А/150  
тушаалын 4 дугаар хавсралт



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
“2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ”**

## ГАРЧИГ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3-6
ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	6-8
ГУРАВ.АЛСЫН ХАРАА	8
ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО	8
ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	9-13
ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	13-14
ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ	15-18
НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ	19
ЕС.ХАВСРАЛТ	20



## НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

“Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн 5.3.“Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.”, 7.4.“Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.” гэсэн зорилтыг дэвшүүлж, төрийн захиргааны байгууллагыг хариуцах асуудлынхаа хүрээнд шаардлагатай үйл ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх нь ирэх 4 жилд баримтлах үйл ажиллагааны зорилго, чиглэл, арга замуудыг тодорхойлж, төрийн бодлого, хууль тогтоомж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.


**Зорилго, зорилт.** Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөгжлийн чиг хандлага, 2021-2024 он хүртэлх хугацаанд баримтлах стратегийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний чиглэлийг тодорхойлоход тус төлөвлөгөөний зорилго оршино.

**Стратеги төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим.** Төлөвлөгөөг “Ухаалаг” (SMART) буюу зорилго тодорхой байх (S-Specific), хэмжиж болохуйц (M-Measurable), зорилгодоо хүрч болохуйц байх (A-Attainable), бодитой байх (R-Relevant), цаг хугацаатай байх (T-Time based) зарчмуудыг агуулсан байхаар боловсруулахыг зорьсон.

**Төлөвлөгөөний хамрах хүрээ.** Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн 2021-2024 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлов.

**Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн.** Энэхүү төлөвлөгөө нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй уялдаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар, түүний орон нутаг дахь газар, хэлтсийн үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөсөн баримт бичиг юм.

Уг төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр мэдээллийн сан бүрдүүлэх, цахим сүлжээний нууцлал, аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах тоног төхөөрөмж, программ хангамжийг шинэчлэх, суурь мэдээллийг бусад байгууллагатай солилцох болон газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санд холбогдох, улсын бүртгэлийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт



шилжүүлэх, чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажлын таатай орчин бий болгох зэрэг олон асуудлыг цогцоор нь үе шаттайгаар шийдвэрлэх явдал юм.

Улсын бүртгэлийн байгууллага нь Монгол Улсын нийслэл, 9 дүүрэг, 21 аймаг, 330 сум суурин, хилийн чанад дахь 43 Дипломат төлөөлөгчийн газарт улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй нь энэ байгууллагын цар хүрээ өргөн байгаагийн илэрхийлэл юм.

Өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарсан тус байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад бодлогын зорилт, үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмбэлэн, хэрэгжүүлэхэд гарч болох саад бэрхшээлүүдийг урьдчилан тооцож, хариу авах арга хэмжээг судалж, төлөвлөгөөнд тусгах зэрэг арга зүйг баримталсан болно. Үүнийг олон улсад хувилбарт төлөвлөлт (scenario planning)-ийн арга гэдэг.

Стратеги төлөвлөгөөг оновчтой, бодитой боловсруулахын тулд бид байгууллагын өмнө тулгамдсан асуудлыг дараах байдлаар тодорхойлж, ач холбогдлын зэрэглэлээр нь эрэмбэлэв.

### 1.1.БАЙГУУЛЛАГЫН ӨМНӨ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

<b>Тулгамдсан асуудлуудын эрэмбэ:</b>		
<b>Нэн их</b>	<b>Их</b>	<b>Дунд</b>
<b>НЭГ.УЛСЫН БҮРТГЭЛИЙН АСУУДЛААР</b>		
Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийг таних Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилт, тоон гарын үсгийн хэрэглээ хангалтгүй.	Улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас авах боломж бүрдээгүй.	Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн сан байхгүй, засаг захиргааны нэгжид суурилсан хаягжилт нэгдсэн стандарт системгүй, тодорхойгүй байгаа нь улсын бүртгэлийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг, төрийн үйлчилгээний шаардлага хангахгүй.
<b>ХОЁР.ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР</b>		
Хүний нөөц, сургалтын мэдээллийн нэгдсэн суурь судалгаа байхгүй.	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөргүй, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлдэггүй.	Орон нутагт боловсон хүчний нөөц дутмаг байдгаас сул орон тоо гарсан үед томилгоо удааширч, улсын бүртгэлийн үйлчилгээ удааших эрсдэл учирдаг. Албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, мэргэшил, туршлага, ур чадвар дутмаг байгаагаас үйл ажиллагаандаа мэргэжлийн алдаа гаргадаг.




<b>ГУРАВ.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР</b>		
Улсын бүртгэлийн ерөнхий газрын барилга цахилгааны эх үүсвэр, нэмэлт нөөцгүй. Дотоодод цахилгаан сүлжээний завсар үйлчилгээнээс шалтгаалж үйл ажиллагаа доголддог.	Техник, тоног төхөөрөмж хүрэлцээгүй, шаардлагатай. (Тухайлбал: Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжийн 85 хувь нь ашиглалтын хугацаа хэтэрсэн)	Төсвийн хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалан шинэ техник, технологийг нэвтрүүлэх боломж бага, хүрэлцээ муу, ихэнх хувь нь хуучирч муудсан.
<b>ДӨРӨВ.САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР</b>		
Байгууллагын үйл ажиллагаа улсын төсвөөс хамааралтай тул батлагдсан төсөв хүрэлцдэггүй, үүнээс шалтгаалж төлөвлөсөн ажил тасалдах, дутуу биелэх зэрэг сөрөг нөлөө гардаг.	Серверийн албан ёсны лицензийг төсвийн хөрөнгөөр худалдан авах боломж бага. Үйлчилгээний байгууллага хүн ихтэйгээс байнгын засвар хийх шаардлага үүсдэг ч төсөв хангалтгүй.	Жил бүрийн цалингийн сангийн хүрэлцээ хангалтгүй, хууль тогтоомжийн дагуу үр дүнгийн урамшуулал өгөх боломжгүй, хүрэлцээгүй төсөв батлагддаг.
<b>ТАВ.АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР</b>		
Улсын бүртгэлийн орон нутаг дахь 31 газар, хэлтсийн 25 нь архивын зориулалтын байргүй, хадгаламжийн сангийн багтаамж дүүрсэн.	Архивын эх нотлох баримт цахимжсан боловч хуулбар нөөц хувь бэлтгэж тусгайлан хадгалах арга хэмжээ аваагүй нь мэдээлэл устах эрсдэлтэй.	Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг Улаанбаатар хотод ННҮТ, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсээс зөөвөрлөж байгаа нь архивын хадгалалт, хамгаалалтын горим зөрчигддөг.

## **1.2.СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн хэрэгцээ, шаардлагын дагуу Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, үйлчилгээ хүргэх арга хэлбэр өөрчлөгдөж байна. Хөгжлийн шаардлагад нийцүүлэн эрх зүйн таатай орчныг бий болгож, улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлэх, архивын эх нотлох баримтыг стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байранд хадгалах, албан хаагчдыг чадавхжуулах, ажиллах таатай орчныг бий болгох дараах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

**Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд:** Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод хүргэхэд чиглэсэн цахим шинэчлэлийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;

**Цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд:** Хуулиар хязгаарлаж тогтоосон иргэний мэдээллийн нууцлалыг хадгалах, төрийн байгууллагын үйлчилгээг авахад хэрэглэгдэх боломжтой, өөрчлөгддөггүй, дахин олгодоггүй, давхарддаггүй, сольдоггүй, хамгаалалтын дугаар буюу тухайн иргэнийг таних иргэний бүртгэлийн дугаарыг ашиглах, тоон гарын үсгийг улсын бүртгэлийн хэрэглээнд нэвтрүүлэх;



**Материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд:** Орон нутаг дахь газар, хэлтсийг архив, үйлчилгээний стандартад нийцсэн байртай болгох, улсын бүртгэлийн үйлчилгээнд ашиглаж буй техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг шинэчлэх, үндэсний баримт бичгийн бичилтийн үйлдвэртэй болох;

**Бусад шинэтгэлийн хүрээнд:** Улсын бүртгэлийн байгууллагын зохион байгуулалт, удирдлага, хүний нөөцийн чадавхийг сайжруулах.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.3-т “Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.” гэж тус тус заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын зорилт, арга хэмжээнүүдийг 2021-2024 онд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн.


Иймд улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд үндэслэн төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, үр ашигтай болгох зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

## ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого”, 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын хүрээнд хийсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын чиг үүргийн шинжилгээнд үндэслэн мандатын шинжилгээг хийв.


Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх хүрээний байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийх, дахин хуваарилах, холбогдох санал дүгнэлтийг боловсруулах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/65 дугаар тушаал батлагдсан.

Уг тушаалын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/429 дугаар тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын чиг үүрэгт шинжилгээ хийх, дахин хуваарилах, холбогдох санал дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах



аргачлал"-ын дагуу улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай хамааралтай 50 гаруй хуулийг судалж, чиг үүргийн шинжилгээ хийсний дүнд Улсын бүртгэлийн байгууллага Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх" ерөнхий чиг үүрэгтэй, 3 үндсэн, 13 дэд чиг үүрэгтэй байгааг тодорхойлсон.

Зураг 1. Улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг тодорхойлсон схем



Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		71
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	4
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	50
<b>ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ-1: ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ</b>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Иргэний улсын бүртгэл хөтлөх	Иргэний улсын бүртгэлийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх	ХЗДХЯ
	Иргэний улсын бүртгэл хөтлөх	-




	үйл ажиллагаанд хяналт тавих	
	Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх	-
	Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалт	-
	Сонгогчийн бүртгэл	СЕХ, ТЕГ, Бүх шатны ИТХ
ҮЧҮ-2:Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх	ХЗДХЯ
	Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих	-
	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх	-
	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалт	-
ҮЧҮ-3:Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх	ХЗДХЯ
	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих	-
	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нотлох баримтын хадгалалт, хамгаалалт	-
	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх	-

### ГУРАВ.АЛСЫН ХАРАА-VISION

*Иргэн төвтэй, тэгш хүртээмжтэй төрийн цахим үйлчилгээг цогцлооно.*

### ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО-MISSION

*Иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, олон улсын жишигт нийцсэн улсын бүртгэлийн тогтолцоог хөгжүүлнэ.*





## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

**SWOT шинжилгээний арга зүй.** Бүртгэлийн байгууллагын тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд салбарын SWOT шинжилгээг холбогдох судалгаа баримтад үндэслэн дараах ерөнхий арга зүйн хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

**Дотоод хүчин зүйл:** Бүртгэлийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг чанаржуулахад чиглэсэн чадавх, менежмент зэрэг дотоод боломжийн эерэг, сөрөг талыг тогтоож, өнөөгийн байдал болон цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох.

**Гадаад хүчин зүйл:** Байгаль орчин, институц (төрийн бодлого, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт, эрүүгийн нөхцөл байдал) зэрэг Бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн таатай болон таагүй нөлөөг тодорхойлох.

Гадаад, дотоод хүчин зүйлсийг нягтлан тодорхойлж, үнэлсний үр дүнд салбарын үйл ажиллагаа бүрийн зорилго, хэрэгжүүлэх стратегийг дараах байдлаар тодорхойлно:

SO - шийдвэр: давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах стратеги;

WO - шийдвэр: сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах стратеги;

ST- шийдвэр: давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах стратеги;

WT - шийдвэр: гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талаа сайжруулах замаар гарах сөрөг үр дагаврыг аль болох багасгах стратеги.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг дор дурдсан байдлаар тодорхойлж байна:

Гадаад орчны нөлөөлөл	Дотоод орчны нөлөөлөл
<p><b>Эдийн засгийн орчин:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Улсын төсвийн байдал</li> <li>• Хууль зүй дотоод хэргийн сайдын багцын төсөв</li> <li>• Олон улсаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр</li> </ul> <p><b>Техник технологийн орчин:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллийн технологи</li> <li>• Орчин үеийн дэвшилтэд техник, технологийн хөгжил</li> <li>• Судалгаа шинжилгээний үр дүн</li> </ul> <p><b>Улс төрийн орчин:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сонгуулийн үр дүн</li> <li>• Хууль зүй, дотоод хэргийн яамны болон</li> </ul>	<p><b>Эрх зүйн орчин, санхүү төсөв</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл</li> <li>• Эрхэм зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчим</li> <li>• Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт</li> <li>• Салбар, нэгжийн бүтэц, зохион байгуулалт</li> <li>• Албан тушаалын тодорхойлолт</li> <li>• Стратеги, зорилт, үйл ажиллагаа</li> <li>• Байгууллагын дотоод журам</li> <li>• Байгууллагын соёл</li> <li>• Байгууллагын санхүүгийн чадавх</li> <li>• Орлогын эх үүсвэр</li> <li>• Өр, авлага</li> <li>• Төсвийн захиран зарцуулалт</li> <li>• Дотоод мэдээллийн систем</li> </ul>

<p>агентлагийн бүтэц</p> <p><b>Эрх зүйн орчин:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хууль, тогтоомж</li> <li>• Бодлого, хөтөлбөр</li> </ul> <p><b>Нийгэм, соёлын орчин:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хотжилт</li> <li>• Хүн амын өсөлт</li> <li>• Амьжиргааны түвшин</li> </ul> <p><b>Хэрэглэгч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд</li> <li>• Иргэд</li> </ul> <p><b>Түншлэгч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн болон төрийн бус байгууллага</li> <li>• Олон улсын байгууллага</li> <li>• Иргэд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод үйл ажиллагааны хяналтын систем</li> </ul> <p><b>Үйл ажиллагаа:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүртгэлийн үйлчилгээ</li> <li>• Үйлчилгээний хүртээмж</li> <li>• Шуурхай байдал</li> </ul> <p><b>Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, судалгаа шинжилгээ</li> <li>• Мэдээллийн аюулгүй байдал</li> </ul> <p><b>Хүний нөөц:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Албан хаагчдын мэргэжил, боловсрол, мэдлэг, ур чадвар, хандлага</li> <li>• Хамт олны уур амьсгал</li> <li>• Нийгмийн баталгаа, эрүүл мэнд</li> <li>• Сургалт, хөгжил</li> <li>• Ажлын байрны байршил</li> <li>• Ажлын байрны тохижилт, эрүүл ахуй</li> </ul>
--	--

### Гадаад орчны шинжилгээ

Боломж	Бэрхшээл
<b>Эдийн засгийн орчин</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны төсвийн зардлыг нэмэгдүүлэх;</li> <li>• Бүртгэлийн үйл ажиллагааг зөвхөн төсвөөс биш бусад олон улсын байгууллага, түүний төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс орны эдийн засгийн чадавх сул тул төсвийн хөрөнгө мөнгө хязгаарлагдмал;</li> <li>• Төрийн эдийн засгийн бодлогоос хамааралтай тул эдийн засгийн нөөцийн баталгаа, тогтвортой найдвартай байдал сул;</li> <li>• Эдийн засгийн байдлаас шалтгаалж, батлагдсан бодлого, хөтөлбөр бүрэн хэрэгждэггүй.</li> </ul>
<b>Техник технологийн орчин</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Орчин үеийн шинэ техник, технологи, мэдээллийн технологийн шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;</li> <li>• Цаасан суурьт үйлчилгээнээс татгалзах;</li> <li>• Цахим гарын үсгийг бүртгэлийн үйлчилгээнд ашиглах, хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дэлхий дахинд шинэ техник, технологийн хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хурдыг гүйцдэггүй;</li> <li>• Төсвийн хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалан шинэ техник, технологийг нэвтрүүлэх боломж бага хүрэлцээ муу, ихэнх хувь нь хуучирч муудсан;</li> <li>• Кибер халдлагад өртөх магадлалтай.</li> </ul>
<b>Улс төрийн орчин</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрөөс хараат байдлыг багасгах, төрийн албаны тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын удирдлага улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж ойр ойрхон солигдох магадлал өндөр;</li> <li>• Улс төрийн нөлөөлөл, удирдлагын арга барилаас шалтгаалж хүний нөөцийн бодлого, тогтвор суурьшил алдагдах.</li> </ul>
<b>Эрх зүйн орчин</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Багц хуульд өөрчлөлт оруулах замаар бүртгэлийн байгууллагын цар хүрээ,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэчлэгдсэн хуулийн зарим зүйл заалт өөр холбогдох хуулийн зүйл заалттай</li> </ul>




<ul style="list-style-type: none"> <li>үйлчилгээг нэмэгдүүлэх;</li> <li>“Нэг иргэн-нэг бүртгэл” үндэсний хөтөлбөрийг батлуулах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>зөрчилддөг;</li> <li>Улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай зарим журам, загвар батлагдаагүй.</li> </ul>
<b>Нийгэм, соёлын орчин</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх боломжтой;</li> <li>Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэх ;</li> <li>Иргэн, хуулийн этгээд өөрөө ирдэг байдлыг багасгах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн сан байхгүй, засаг захиргааны нэгжид суурилсан хаягжилт нь нэгдсэн стандарт системгүй, тодорхойгүй байгаа нь бүртгэлийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг, төрийн үйлчилгээний шаардлага хангахгүй.</li> </ul>
<b>Хэрэглэгч</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Бүртгэлийн үйл ажиллагаанд олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх;</li> <li>Өндөр хөгжилтэй улс орнуудтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;</li> <li>Олон улсын байгууллагаас төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар явуулах зэргээр дэмжлэг туслалцаа авах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, яам, агентлаг, салбар дундын хамтын ажиллагаа сайтар хөгжөөгүй;</li> <li>Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох байдал хязгаарлагдмал, мэдээлэл зөрүүтэй, улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас авах боломж бүрдээгүй;</li> <li>Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар харилцан адилгүй.</li> </ul>

### Дотоод орчны шинжилгээ

Давуу тал	Сул тал
<b>Эрх зүйн орчин, санхүү төсөв</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Байгууллага үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон;</li> <li>Эрхэм зорилго, стратеги нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, батлагдсан бодлого, хөтөлбөр, бусад эрх зүйн баримт бичгийн зорилтуудтай уялдсан;</li> <li>Монгол Улсын засаг захиргааны нэгж бүрт улсын бүртгэлийн ажилтантай бөгөөд төвлөрсөн босоо удирдлагатай;</li> <li>Архив үйлчилгээний цогцолбор төвийн байрыг ашиглалтад хүлээн авсан;</li> <li>Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн Төрийн албаны төв байгууллагаар хянуулж, батлуулсан;</li> <li>Үйл ажиллагаа явуулах дүрэм, журам, эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн;</li> <li>Байгууллагын соёл тодорхой хэмжээнд төлөвшсөн;</li> <li>Байгууллагын үйлчилгээний стандартыг баталж, мөрдүүлдэг;</li> <li>Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн шугамаар нэмэлт санхүүжилт шийдэгддэг;</li> <li>Өр, авлага харьцангуй бага;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллага алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсээ томъёолоогүй;</li> <li>Орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталдаг учраас шаардлагатай орон тоог тухай бүр нэмэх боломжгүй;</li> <li>Засаг захиргааны нэгжийн байршил, хүн амын тооноос хамаарч орон нутаг дахь нэгжийн зохион байгуулалтыг оновчтой, ачааллыг тэнцвэржүүлсэн байдлаар тогтооход бэрхшээлтэй;</li> <li>Батлагдсан дүрэм, журмыг албан хаагчид бүрэн мөрдөж ажилладаггүй;</li> <li>Санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалж, төлөвлөгдсөн асуудлыг хугацаанд нь гүйцэтгэж чаддаггүй;</li> <li>Байгууллагын үйл ажиллагаа улсын төсвөөс хамааралтай тул батлагдсан төсөв хүрэлцдэггүй, үүнээс шалтгаалж төлөвлөсөн ажил тасалдах, дутуу биелэх зэрэг сөрөг нөлөө гардаг;</li> <li>Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар, 9 дүүрэг, 16 аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс өөрийн байргүй, өөрийн хэлтсийн байртай зарим нь хуучирч муудсан, зарим</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн захиран зарцуулалт нээлттэй;</li> <li>• Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй нэгжийн тоо нэмэгдсэн;</li> <li>• Дотоод үйл ажиллагаанд тавих хяналт сайн, албан хаагч бүр гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан гаргаж ажилладаг.</li> </ul>	<p>нь үйлчилгээний болон эрүүл ахуйн шаардлага хангахгүй нөхцөлд ажилладаг;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний гадаад паспортад бичилт хийх үйлдвэр байхгүй, хувийн компаниар хийлгэдэг;</li> <li>• Батлагдсан дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих механизм хангалтгүй;</li> <li>• Ажил мэргэжлийн алдаа гарахаас урьдчилан сэргийлэх механизм хэрэгжүүлдэггүй;</li> <li>• Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тасралтгүй тавих асуудал сул;</li> <li>• Аливаа ажил тушаал, шийдвэрээр явагддаг тул албан хаагчдын идэвх санаачилга сул.</li> </ul>
<b>Үйл ажиллагаа</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Аливаа үйл ажиллагаа тушаал шийдвэр, захирах, захирагдах ёсны хэм хэмжээнд явагддаг;</li> <li>• Улсын бүртгэлийн нэгдсэн архивт хадгалагдаж буй улсын бүртгэлийн эх нотлох баримтын 85 хувь цахимжсан, бүртгэлийн нэгдсэн архивын системтэй;</li> <li>• Улсын бүртгэлийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн;</li> <li>• Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд бүх сум, сууринг холбосон;</li> <li>• Лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр олгох нөхцөл бүрдсэн;</li> <li>• Төрийн болон төрийн бус байгууллагуудтай дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл солилцдог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цахим гарын үсгийн хэрэглээ улсын хэмжээнд хангалтгүй байгаа тул цахим үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээдийн тоо хязгаарлагдмал;</li> <li>• Сум, хорооноос хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэггүй;</li> <li>• Цахимаар олгож буй лавлагаа, мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас цаасан хэлбэрээр олгодог;</li> <li>• Хаягийн мэдээллийн нэгдсэн санд холбогдоогүй;</li> <li>• Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн сангууд нэгтгэгдээгүй.</li> </ul>
<b>Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдал</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын хамгийн том буюу 120 тб хэмжээтэй 37 цахим мэдээллийн сантай;</li> <li>• Орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа;</li> <li>• Төсөл хөтөлбөрүүд техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хангах чиглэлээр дэмжлэг үзүүлж байгаа;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Техник, тоног төхөөрөмж хүрэлцээгүй, сайжруулах шаардлагатай; (Тухайлбал: Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжийн 85 хувь нь ашиглалтын хугацаа хэтэрсэн)</li> <li>• Төсвөөс шалтгаалан шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч чаддаггүй;</li> <li>• Мэдээллийн сан удирдах системүүдийн лицензийн хугацаа дууссанаас хөгжүүлэлт хийх боломжгүй;</li> <li>• Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй сүлжээний топологи зураглалгүй;</li> <li>• Албан хаагчид компьютер, мэдээллийн санд нэвтрэх нууц үгийг тогтмол давтамжтай сольж хэвшээгүй;</li> <li>• Улсын бүртгэлийн байгууллагын сүлжээний аюулгүй байдал, холболтын үйл ажиллагаа хангалтгүй;</li> <li>• Албан ёсны лизенцтэй программ хангамж ашигладаггүй;</li> <li>• Хортой кодны эсрэг программ хангамжийг</li> </ul>



	<p>нэгдсэн байдлаар ашигладаггүй;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Программ хангамжийн эх кодыг өөр серверт хадгалдаггүй.</li> </ul>
<b>Хүний нөөц</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн бүрдүүлэлт тухай бүр хийгдэж мэргэжлийн боловсон хүчнээр зохих түвшинд хангагдсан;</li> <li>• Байгууллагын нэр хүнд сайн тул тус албанд ажилд орох сонирхол нийгэмд нэмэгдсэн;</li> <li>• Албан хаагчдын 50 хүртэлх хувь нь тогтвор суурьшилтай ажилладаг;</li> <li>• Орон нутаг дахь газар, хэлтсийн албан хаагчдын цалингийн зэрэглэл өндөр;</li> <li>• Ажлын байрны шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр зохих түвшинд хангагдсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөц, сургалтын мэдээллийн суурь судалгаа байхгүй;</li> <li>• Албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, мэргэшил, туршлага, ур чадвар дутмаг;</li> <li>• Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөргүй;</li> <li>• Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөргүй.</li> </ul>

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ


### Салбарын SWOT шинжилгээний үр дүн, баримтлах стратеги:

<b>SO</b> - салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги	<b>WO</b> - салбарын сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги
<ul style="list-style-type: none"> <li>- Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төлөвлөлтийг оновчтой хийх;</li> <li>- Олон улсын жишигт нийцсэн шинэ санал санаачилга, технологи нэвтрүүлэх;</li> <li>- Улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, шуурхай байдлыг хангах замаар хүртээмжийг нэмэгдүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэшсэн төрийн албыг бэхжүүлж, хүний хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;</li> <li>- Ажлын таатай орчныг бий болгож, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;</li> <li>- Материаллаг баазыг бэхжүүлэх замаар орон нутаг дахь газар, хэлтсийг архив, үйлчилгээний стандартын шаардлага хангасан байраар хангах.</li> </ul>
<b>ST</b> - салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөлөөг даван туулах боломжийг ашиглах стратеги	<b>WT</b> - салбарын гадаад орчны таагүй нөхцөлд сул талаа сайжруулах замаар сөрөг үр дагаврыг даван туулах стратеги
<ul style="list-style-type: none"> <li>- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;</li> <li>- Хамтын ажиллагааг өргөжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн менежментийн тогтолцоог хөгжүүлэх.</li> </ul>

## ЗУРГАА. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

### 6.1. Стратегийн зорилго

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дунд хугацааны стратегийн зорилго нь улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд үндэслэн төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэхэд оршино.



## **6.2.Стратегийн зорилт**

Стратегийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

6.2.1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн байгууллага байна.

6.2.2.Цахим бүртгэл, мэдээллийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.

6.2.3.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдлыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

6.2.4.Гадаад улстай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

6.2.5.Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.

Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хангахад зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, орон нутаг дахь газар, хэлтсийн оролцоо, уялдаа холбоо, харилцан хамтын ажиллагаа чухал билээ.



**Төлөөлөгөөг баталсан:**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

/Албан тушаал/



**Төсвийн ерөнхийлөн захирагч**

/Х.НЯМБААТАР/

.....

/Он, сар, өдөр/

**Төлөөлөгөө боловсруулсан:**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА

/Албан тушаал/



**Төсвийн төвлөрүүлэн захирагч**

/Д.ДЭЛГЭРСАЙХАН/

.....

/Он, сар, өдөр/

**ДОЛОО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021-2024 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<b>ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН НЭР: ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ</b>					
<b>ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР:</b>					
1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.	1.1. Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийг үе шаттайгаар архив, үйлчилгээний байртай болгох.	Ашиглалтад авсан архив, үйлчилгээний байрны тоо	5	15	Улсын төсөв
	1.2. Үндэсний баримт бичгийн бичилтийн үйлдвэрийг байгуулах.	Бичилтийн үйлдвэрийн тоо	1	2	Улсын төсөв
	1.3. Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэх.	Иргэний дугаар бүртгэлийн хэрэглээнд нэвтэрсэн эсэх.	0	1	Улсын төсөв
	1.4. Тоон гарын үсгийг улсын бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлэх.	Тоон гарын үсгийг улсын бүртгэлийн үйлчилгээнд ашиглаж эхэлсэн эсэх.	0	1	Улсын төсөв
	1.5. Улсын бүртгэлийн цахим гэрчилгээг үйлчилгээнд нэвтрүүлэх.	Улсын бүртгэлийн цахим гэрчилгээг үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх.	0	1	Улсын төсөв
	1.6. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын системийг хөгжүүлэх.	Эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон эрсдэл буурсан байдал хувиар	0	1	Улсын төсөв
2. Цахим бүртгэлийг	2.1. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлэх.	Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, төрөл	26	51	Улсын төсөв






Цахим танхимаар үзүүлсэн эсэх	Цахим үйлчилгээний үйлчилгээ	0	1	Төсөл хөтөлбөр
хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.	2.2. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний танхимтай болох.	0	1	Төсөл хөтөлбөр
	2.3. Улсын бүртгэлийн архивын баримтыг бүрэн цахимжуулах.	85	100	Улсын төсөв
	2.4. Улсын бүртгэлийн мэдээлэл солилцоо болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх.	50	100	Улсын төсөв
	2.5. Нотариаттай дундын мэдээллийн сангаар мэдээлэл солилцох.	11	270	Улсын төсөв
	2.6. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох	0	100	Улсын төсөв
	2.7. Сум, хорооноос хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх.	5	20	Улсын төсөв
	3.1. Цахим мэдээллийн сангийн нууцлал, түүний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах.	0	100	Улсын төсөв
	3.2. Мэдээллийн сангийн нөөцлөлтийг автомат горимоор хийх, мэдээллийн санг хянах программ хангамж боловсруулах, хэрэглээнд нэвтрүүлэх	0	1	Улсын төсөв
	3.3. Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хангах хяналтын систем нэвтрүүлэх.	0	1	Улсын төсөв
	3.4. Улсын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлдлийн систем, Ogcse	0	100	Төсөл хөтөлбөр



өгөгдлийн санг албан ёсны лицензжүүлэх шийдвэрлэх.	тоо, хувиар			
3.5.Улсын бүртгэлийн нэгдсэн санд зөрчлийн бүртгэл хяналтын систем нэвтрүүлэх.	Хяналтын нэгдсэн системийг нэвтрүүлсэн эсэх	0	31	Төсөл хөтөлбөр
3.6.Хортой кодны эсрэг хамгаалах программ хангамжийг цогцоор шийдэх.	Лицензийн тоо, хувиар	50	100	Төсөл хөтөлбөр
3.7.Эрчим хүчний нөөц нэмэлт эх үүсвэртэй болох.	Өөрийн мэдлийн эрчим хүчний эх үүсвэртэй болсон эсэх	0	1	Улсын төсөв
3.8.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх.	Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хувь	15	100	Төсөл хөтөлбөр
3.9.Мэдээллийн сангуудын нөөцлөлт болон хөргөлтийн тоног төхөөрөмжөөр хангах.	Худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо, хувиар	0	100	Төсөл хөтөлбөр
4.Гадаад улстай ажиллагааг өргөжүүлнэ.	Гадаадын улс орон, олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах гэрээ хэлэлцээр, санамж бичиг, төслийн тоо	2	3	Улсын төсөв
4.1.Гадаадын улс орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах.	Гадаадын улс орон, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан албаны сургалтын тоо	1	5	Төсөл хөтөлбөр
	Гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлал, уулзалт, алба хаагчдын гадаад улсад албан	2	4	Төсөл хөтөлбөр



		ТОМИЛОЛТЫН ТОО				
5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.	5.1. Хүний хөтөлбөр хэрэгжүүлэх.	хөгжлийн	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв
	5.2. Албан хаагчдын баталгааг хангах хэрэгжүүлэх.	нийгмийн хөтөлбөр	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв
	5.3. Хүний нөөц, нэгдсэн системийг нэвтрүүлэх.	сургалтын хэрэглээнд	Ашиглалтын хувь	0	100	Төсөл хөтөлбөр



**НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН  
УЯЛДАА, ЗУРАГЛАЛ**

